



ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
И.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.08.13. № 47.

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын үр дүнд нийцлийн аудит хийх явцад 82,504,580.50 /Наян хоёр сая таван зуун дөрвөн мянга таван зуун наян төгрөг тавин мөнгө / төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 13 тоот тогтоолоор баталсан Өлзийт сумын 2017 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг Төсвийн тухай хуульд нийцсэн эсэхийг хянаж үзэхэд нийт 15,177,500.00 төгрөгийн **“Төсөл хөтөлбөр арга хэмжээ”**, /Хууль сурталчлах хөтөлбөр, нийгмийн хүрээнд иргэдийн дунд зохион байгуулагдах хөтөлбөр, Иргэд малчид орон нутгийн удирдлагын хамтын ажиллагаа хөтөлбөр/ ажлууд нь иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж болохгүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

2. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа “ЖИ МОБАЙЛ” ХХК- аас тус сумын нутагт дэвсгэрт байрлах холбооны 30 м цамхаг, 4x4 хэмжээтэй байр, 10x10 харьцаатай хашаа, газардуулга, цахилгааны шугамыг ашигласны түрээсийн төлбөрийн 660,000.00 төгрөгийг, сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй зориулалтын бус урсгал зардалд буюу **“Гамшгаас хамгаалах сургалт”**-ын ажилд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно/, 60.3.4-т /Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно/, 60.3.6-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/, 63 дугаар зүйлийн 63.1.-д /Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна/, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4

1300900712

дүгээр зүйлийн 4.4-т /Аймаг нийслэл сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх болон урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй/, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журмын 6 дугаар зүйлийн 6.3.3.-т /хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх/ гэж заасныг

3. Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны санхүүгийн тайлангаар 63,667,080.50 төгрөгийн авлага, 3,000,000.00 төгрөгийн өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/ 20.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах,/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын ,4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй , зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн;/ , 4.1.4-д /Байгууллага иргэдтэй үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй/ , 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийн хуулийн шаардлагыг хангаагүй, зориулалтын бус зардалд зарцуулахаар төлөвлөсөн 15,177,500.00 /Арван таван сая нэг зуун далан долоон мянга таван зуун/ төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг жагсаалтаас хасч тодотгох,

2. Харилцагч байгууллагатай өглөг, авлагын тооцоог нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, барагдуулах ажлыг зохион байгуулах.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг батлахдаа иргэд олон нийтийн саналыг авсан, нийтийн эрх ашигт нийцэхүйц болон бусад шаардлагыг хангасан хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх.

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 04 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Өлзийт сумын Засаг дарга И.Эрдэнбилэг, засаг даргын орлогч А.Эрдэнэбат, нягтлан бодогч Н.Буянжаргал нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

АХЛАХ ШИНЖЭЭЧ



ЗКА0006 9033478

Д.ИХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ ДАРГА И.ЭРДЭНЭБИЛЭГ

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ А.ЭРДЭНЭБАТ

НЯГТЛАН БОДОГЧ Н.БУЯНЖАРГАЛ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.